



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СУДАЛГАА

2025 ОНЫ I УЛИРАЛ



Улаанбаатар хот
2025 он

 МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Сүхбаатар дүүрэг, Бага тойруу
Засгийн газрын III байр

 976-11-326414, 976-51-265543

 www.nso.mn, www.1212.mn

 information@nso.mn

АГУУЛГА

ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН АРГАЧЛАЛ.....	3
1. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО.....	4
2. АЖИЛЛАГЧИД.....	9
3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ	14
3.1. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч.....	16
3.2. Ажилгүй хүн	17
3.3. Боломжит ажиллах хүч.....	19
4. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ.....	21
5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ХАМРАГДААГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУД.....	23

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо, хүйсээр	5
Хүснэгт 2. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар	10
Хүснэгт 3. Ажиллагчид, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр.....	12
Хүснэгт 4. Ажиллагчид, аж ахуйн нэгж, байгууллагын төрлөөр, хүйсээр	13
Хүснэгт 5. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, хувиар, 2024 оны 3 дугаар улиралд.....	14
Хүснэгт 6. Хөдөлмөрийн дутуу ашиглалт, бүс, аймаг, нийслэлээр.....	15
Хүснэгт 7. Ажилгүй хүн, ажилгүйдлийн түвшин, хүйсээр, байршил, бүсээр	17
Хүснэгт 8. Ажилгүй хүн, насны бүлгээр	18
Хүснэгт 9. Ажилгүй хүн, боловсролын түвшин, хүйсээр	18
Хүснэгт 10. Боломжит ажиллах хүч, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар	20
Хүснэгт 11. Итгэл алдарсан ажил хайгчид, насны бүлэг, хүйсээр.....	20
Хүснэгт 12. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, бүс, насны бүлгээр	21
Хүснэгт 13. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, шалтгаанаар, мянган хүнээр	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. 15, түүнээс дээш насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо.....	4
Зураг 2. Хөдөлмөрийн насны хүн амын бүтэц, мянган хүнээр, улирлаар	4
Зураг 3. Ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин, улирлаар	7
Зураг 4. Ажиллах хүчний оролцооны болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин, насны бүлэг, хувиар	7
Зураг 5. Ажиллах хүчний оролцооны түвшин, насны бүлэг, хүйсээр, хувиар.....	7
Зураг 6. Ажиллах хүчний оролцооны түвшин, гэрлэлтийн байдал, хүйсээр, хувиар	8
Зураг 7. Ажиллах хүчний оролцооны түвшин, боловсролын түвшин, хүйсээр, хувиар.....	9
Зураг 8. Ажиллагчид, хөдөлмөр эрхлэлтийн түвшин, аймаг, нийслэлээр	11
Зураг 9. Хөдөлмөрийн статистикийн зарим үзүүлэлтүүд, 2023 оны 4 дүгээр улиралд	11
Зураг 10. Ажиллагчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, мянган хүнээр.....	12
Зураг 11. Ажиллагчид, эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшнээр, улирлаар, дүнд эзлэх хувиар.....	13
Зураг 12. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшнүүд, улирлаар	14
Зураг 13. Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшнүүд, насны бүлгээр, хувиар, 2024 оны 3 дугаар улиралд.....	14
Зураг 14. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, насны бүлгээр	16
Зураг 15. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, ажиллаж буй ажил мэргэжлээр, дүнд эзлэх хувиар	16
Зураг 16. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар	17
Зураг 17. Ажилгүйдлийн түвшин, насны бүлэг, хүйсээр	18
Зураг 18. Ажилгүй хүн, өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар, дүнд эзлэх хувиар.....	199
Зураг 19. Боломжит ажиллах хүч, бүсээр, дүнд эзлэх хувиар	19
Зураг 20. Сүүлийн 30 хоногт ажил хайгаагүй боломжит ажиллах хүч, ажил хайгаагүй шалтгаан, дүнд эзлэх хувиар.....	20
Зураг 21. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын бүтэц, мянган хүн болон дүнд эзлэх хувь	21
Зураг 22. Ажиллах хүчнээс гадуурх хүн амын өөрчлөлт, ажилгүй байгаа шалтгаанаар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, мян.хүн.....	22

Зураг 23. 15-24 насны нийт залуучуудад хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувь, хүйсээр.....	23
Зураг 24. 15-24 насны нийт залуучуудад хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувь, боловсролын түвшнээр, хүйсээр.....	24

ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН АРГАЧЛАЛ

Үндэсний Статистикийн хороо нь олон улсын нийтлэг жишиг аргачлалын дагуу 2006 оноос эхлэн “Ажиллах хүчний түүвэр судалгаа” (АХС) -г улирлаар явуулж байна.

Энэхүү **судалгааны зорилго** нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тухайн хугацаа буюу сүүлийн 7 хоногоор тодорхойлж, дүн шинжилгээ хийх тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

Судалгааг 2006-2018 онуудад Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 1982 оны 13-р бага хурлын тогтоолын дагуу боловсруулагдсан Монгол Улсын хөдөлмөрийн статистикийн аргачлал, арга зүйн дагуу явуулж байсан.

Харин **2019 оноос эхлэн шинэ аргачлал, ойлголт тодорхойлолтын дагуу явуулж байна**. Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 2013 онд болсон 19-р бага хурлаар 1982 оны 13-р бага хурлаас баталсан аргачлал нь хөдөлмөрийн зах зээлийн бодит дүр зургийг төдийлөн илэрхийлж чадахгүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлоход дутагдалтай байгааг онцолж, аргачлалыг шинэчлэх шийдвэр гаргасан юм. Тухайлбал, ажилгүйдлийн түвшин дангаараа ажиллах хүчний дутуу ашиглалтыг бүрэн харуулж чадахгүй байгаа тул ихэнх орнуудын ажиллах хүч, ажилгүйдлийн түвшнийг тооцоход ашиглаж байгаа эдийн засгийн идэвхтэй хүн ам, хөдөлмөр эрхлэлт, ажилгүйдэл, бүрэн бус ажил эрхлэлтийн үзүүлэлтүүдийг тооцох аргачлалыг шинэчлэхийг чухалчилсан.

Маш хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг бодитоор харуулахын тулд бид олон улсын шинэ аргачлалыг өөрийн орны онцлогт тусган нэвтрүүлж, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал”-ыг батлан 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

Хөдөлмөрийн статистикийн аргачлалыг шинэчилснээр хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээлэл, түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүрэн харуулах статистикийн үзүүлэлтийг шинээр бий болгож, бодлого боловсруулагчдыг зохих мэдээллээр хангах юм.

Олон улсын хөдөлмөрийн статистикчдын 19-р бага хурлын “Ажил, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний дутуу ашиглалт”-ын талаарх тогтоолын дагуу хөдөлмөрийн статистикийн ойлголт, аргачлалд гарсан томоохон өөрчлөлтийг дурдвал:


- **Цалин хөлс, орлого олох зорилгоор ажиллаж буй ажиллагчдын** тодорхойлолт, үзүүлэлтийг сайжруулсан (Ингэснээр бусад төрлийн ажил, тухайлбал, өөрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг ажиллагчдаас ялгах боломжтой болж байгаа юм).
- **Хөдөлмөрийн насны хүн амыг** 15 ба түүнээс дээш насаар тогтоосон.

- Ажиллагчдын **үндсэн ажлын** шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.
- **Ажилгүй хүний** шалгуур шинэчлэгдэн, цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа гэсэн 3 шалгуурыг хангасан хүнийг хэлэх болсон. Өмнө нь “сүүлийн 2 шалгуурын аль нэгийг нь хангах” гэж авч үзэж байсан. Мөн насны дээд хязгааргүй болсон.
- Ажиллах хүчний дутуу ашиглалтыг хэмжих уламжлалт үзүүлэлт буюу ажилгүй хүн, ажилгүйдлийн түвшнээс илүү өргөн хүрээний **хөдөлмөрийн дутуу ашиглалт, түүний ТҮВШНҮҮД** бүхий шинэ үзүүлэлтүүдийг бий болгосон.

1. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО

Ажиллах хүчний судалгааны 2025 оны 1 дүгээр улирлын дүнгээр улсын хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15, түүнээс дээш насны 2.4¹ сая хүн байна.

ЗУРАГ 1. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, 2025 оны 1 дүгээр улиралд



Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 1459.1 (62.0%) мянга нь ажиллах хүч, 893.7 (38.0%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 54.7 (3.9%) мянган хүнээр, ажиллах хүчнээс гадуурх хүн ам 83 (0.01%) хүнээр тус тус өссөн байна.

Ажиллах хүчний² 1380.1 (94.6%) мянга нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчид, 79.0 (5.4%) мянга нь

хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох ажилгүй хүн (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна.


Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 29.6 (3.3%) мянга нь боломжит ажиллах хүч (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан эсвэл тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна. Боломжит ажиллах хүчний бүлэг нь тухайн сум, орон нутагт нь ажлын байр бий болох эсвэл ажил хийх нөхцөл нь бүрдвэл хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож эхлэх, ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа хүн ам юм. Энэ

¹ Энд өрхөөс гадуур амьдарч байгаа гадаадад суугаа иргэд болон цэрэг, хоригдлын тоог оруулахгүй.

² Тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм.

утгаараа ажиллах хүчинд ороход боломжит бүлэг гэж үзэн, ажиллах хүчинд нэмж, өргөн утгаар нь өргөтгөсөн ажиллах хүч гэж авч үздэг.

ЗУРАГ 2. ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН БҮТЭЦ, мянган хүнээр, улирлаар



ХҮСНЭГТ 1. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО, хүйсээр

Үндсэн үзүүлэлтүүд	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Улсын хэмжээнд						
Ажиллах хүч	1,459,054	100.0	798,953	54.8	660,102	45.2
Ажиллагчид	1,380,098	100.0	751,337	54.4	628,762	45.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	1,121	100.0	621	55.4	500	44.6
Ажилгүй хүн	78,956	100.0	47,616	60.3	31,340	39.7
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	893,727	100.0	326,726	36.6	567,001	63.4
Боломжит ажиллах хүч	29,551	100.0	15,826	53.6	13,725	46.4
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	864,176	100.0	310,900	36.0	553,276	64.0
Ажиллах хүчний оролцооны түвшин, %		62.0		71.0		53.8
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %		58.7		66.7		51.2
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %		7.4		7.9		6.8
Ажилгүйдлийн түвшин, %		5.4		6.0		4.7
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %		5.5		6.0		4.8
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %		7.3		7.8		6.7
Хот						
Ажиллах хүч	1,090,182	100.0	595,533	54.6	494,649	45.4
Ажиллагчид	1,020,030	100.0	552,406	54.2	467,624	45.8

Үндсэн үзүүлэлтүүд	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	345	100.0	345	100.0	0	0.0
Ажилгүй хүн	70,153	100.0	43,127	61.5	27,025	38.5
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	781,030	100.0	283,908	36.4	497,121	63.6
Боломжит ажиллах хүч	27,640	100.0	15,078	54.6	12,561	45.4
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	753,390	100.0	268,830	35.7	484,560	64.3
Ажиллах хүчний оролцооны түвшин, %		58.3		67.7		49.9
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %		54.5		62.8		47.2
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %		8.8		9.6		7.8
Ажилгүйдлийн түвшин, %		6.4		7.2		5.5
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %		6.5		7.3		5.5
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %		8.7		9.5		7.8
Хөдөө						
Ажиллах хүч	368,872	100.0	203,420	55.1	165,452	44.9
Ажиллагчид	360,068	100.0	198,931	55.2	161,137	44.8
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	775	100.0	276	35.5	500	64.5
Ажилгүй хүн	8,804	100.0	4,489	51.0	4,315	49.0
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	112,697	100.0	42,818	38.0	69,879	62.0
Боломжит ажиллах хүч	1,912	100.0	748	39.1	1,164	60.9
Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам	110,785	100.0	42,070	38.0	68,715	62.0
Ажиллах хүчний оролцооны түвшин, %		76.6		82.6		70.3
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин, %		74.8		80.8		68.5
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %		3.1		2.7		3.6
Ажилгүйдлийн түвшин, %		2.4		2.2		2.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %		2.6		2.3		2.9
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %		2.9		2.6		3.3

Ажиллах хүчний 1090.2 (74.7%) мянга нь хот, суурин газарт, 368.9 (25.3%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байгаа бол ажиллах хүчнээс гадуурх хүн амын 781.0 (87.4%) мянга нь хот, суурин газарт, 112.7 (12.6%) мянга нь хөдөө орон нутагт амьдарч байна. Ажиллах хүчнээс гадуурх хүн ам хөдөө орон нутагт бага байгаа нь ажиллах хүчний оролцооны түвшин өндөр гарахад нөлөөлжээ.

Хөдөлмөрийн насны хүн амын бүтцийн дээрх (зураг-2) өөрчлөлтийн улмаас ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 0.9 нэгж хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 0.7 нэгж хувиар тус тус өссөн байна.


ЗУРАГ 3. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, улирлаар



Ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) буюу хөдөлмөрийн насны хүн амд ажиллах хүчний эзлэх хувийн жин 62.0 хувь, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 71.0 хувь, эмэгтэйчүүдийнх 53.8 хувьтай байна. Эрэгтэйчүүдийн АХОТ эмэгтэйчүүдийнхээс 17.2 нэгж хувиар өндөр байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин буюу хөдөлмөрийн насны хүн амд ажиллагчдын эзлэх хувийн жин 58.7 хувь, хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийнх 66.7 хувь, эмэгтэйчүүдийнх 51.2 хувь байна.


ЗУРАГ 4. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ БОЛОН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, насны бүлэг, хувиар



Ихэнх насны бүлэгт эрэгтэйчүүдийн ажиллах хүчний оролцооны түвшин эмэгтэйчүүдийнхээс их байна. Тухайлбал, 25-29 (5.5 нэгж хувь) насны бүлэгт хамгийн өндөр зөрүүтэй, 30-34 (4.9 нэгж хувь), 40-44 (4.8 нэгж хувь), 45-49 насны бүлэгт аажмаар буурч 4.0 нэгж хувийн зөрүүтэй болж байна. Энэ нь 20-39 насны бүлгийн эмэгтэйчүүд бусад насны эмэгтэйчүүдтэй харьцуулахад хүүхэд төрүүлэх, асрах зорилгоор ажиллах хүчний эгнээнээс

гардаг, хүүхдүүд нь өсөж томрохын хирээр 40 ба түүнээс дээш насны бүлгийн эмэгтэйчүүд ажиллах хүчний эгнээнд эргэн ордогтой холбоотой байж болно. Мөн 55-59 насны бүлэгт эрэгтэйчүүдийн оролцоо эмэгтэйчүүдийнхээс 16.5 нэгж хувиар их байгаа нь өндөр насны тэтгэвэрт гаргах насны зөрүүтэй байдалтай холбоотой байж болно.


ЗУРАГ 5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, насны бүлэг, хүйсээр, хувиар



Хөдөлмөрийн насны хүн амын АХОТ нь гэрлэлтийн байдлаас хэрхэн хамаарч байгааг авч үзвэл хамгийн бага нь бэлэвсэн хүмүүсийн хувьд 32.2 хувь, хамгийн өндөр нь тусгаарласан хүмүүсийн хувьд 76.4 хувь, гэрлэсэн батлуулсан хүмүүсийн хувьд 70.9 хувь байна.


Гэр бүл тусгаарласан эмэгтэйчүүдийн АХОТ бусад бүлгийн эмэгтэйчүүдээс илүү өндөр буюу 79.5 хувь байгаа бол бэлэвсэн хүмүүсийн АХОТ бага буюу 31.0 хувь байгаа нь тэдний настай холбоотой ба нас ахих тусам ажиллах хүчний оролцооны түвшин буурах хандлагатай байна. Мөн АХОТ-ний хүйсийн ялгаа гэрлэсэн ч гэрлэлтээ батлуулаагүй хүн амын хувьд хамгийн их буюу 22.9 нэгж хувиар зөрүүтэй байна.

ЗУРАГ 6. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, гэрлэлтийн байдал, хүйсээр, хувиар



Ажиллах хүчний оролцооны түвшнийг боловсролын түвшнээр авч үзэхэд, магистрын боловсролын түвшинд 82.3 хувь байгаа нь өндөр үзүүлэлттэй байна. Хүйсээр авч үзэхэд, дипломын дээдээс бусад бүх шатны боловсролын түвшинд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээс 7.6-29.1 нэгж хувиар их байна.

ЗУРАГ 7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, ХҮЙСЭЭР, ХУВИАР



2. АЖИЛЛАГЧИД

Ажиллах хүчний 1.4 (94.6%) сая нь ажиллагчид³, тэдгээрийн 1.1 (0.1%) мянга нь хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид⁴ байна.

³ Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (заалт 27, ОУХС-ын 19-р бага хурлын тогтоол-1).

⁴ Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).


Эдийн засгийн үйл ажиллагааны салбарыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын (37.4 мянгаар), боловсруулах үйлдвэрлэл (21.3 мянгаар), тээвэр ба агуулахын үйл ажиллагаа (14.4 мянгаар), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (9.8 мянгаар), зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (6.8 мянгаар), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (4.2 мянгаар), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (3.6 мянгаар) салбарын ажиллагчид тус тус өссөн байна. Харин боловсролын салбар (19.3 мянгаар), санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (13.0 мянгаар), цахилгаан, хий, уур, агааржуулалт (4.1 мянгаар), үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа (4.1 мянгаар) салбарын ажиллагчид тус тус буурсан байна.

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар

Салбар	2024 I-III	2024 X-XII	2025 I-III	2025 I-III		2025 I-III	
				2024 I-III	2024 X-XII	мян.хүн	хувь
Бүгд	1332.6	1353.4	1380.1	47.5	3.6	26.7	2.0
ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур	342.0	321.3	379.4	37.4	10.9	58.1	18.1
Уул уурхай, олборлолт	82.8	67.1	80.7	-2.2	-2.6	13.6	20.3
Боловсруулах үйлдвэрлэл	106.5	101.3	127.8	21.3	20.0	26.5	26.2
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	23.9	25.0	19.8	-4.1	-17.3	-5.2	-20.7
Усан хангамж, бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	5.3	8.8	6.9	1.6	30.3	-1.9	-21.9
Барилга	85.2	96.1	82.3	-2.9	-3.4	-13.8	-14.4
Бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ	183.2	190.6	187.4	4.2	2.3	-3.2	-1.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	69.4	81.5	83.8	14.4	20.7	2.3	2.8
Зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	33.0	42.5	39.8	6.8	20.7	-2.8	-6.5
Мэдээлэл, холбоо	22.0	20.3	22.2	0.2	0.9	1.9	9.2
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	35.4	27.9	22.4	-13.0	-36.7	-5.5	-19.7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6.0	2.7	2.0	-4.1	-67.4	-0.7	-26.2
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	15.4	23.3	19.0	3.6	23.3	-4.3	-18.4
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	18.3	13.8	14.8	-3.5	-19.3	1.0	7.3
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	86.8	94.5	83.6	-3.2	-3.7	-10.9	-11.5
Боловсрол	124.4	130.0	105.0	-19.3	-15.5	-25.0	-19.2
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	54.9	59.1	54.8	-0.1	-0.1	-4.3	-7.3
Урлаг, үзвэр, тоглоом наадам	14.0	13.6	12.2	-1.8	-13.0	-1.4	-10.2
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23.1	32.7	32.9	9.8	42.4	0.2	0.7
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	0.0	1.3	2.0	2.0	-	0.6	48.6
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0.9	0.0	1.4	0.6	65.9	1.4	-

Тухайн орон нутгийн нийт хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувь нь хөдөлмөрийн зах зээл дээр оролцож цалин хөлс, орлого олж байгааг илэрхийлэх “Хөдөлмөр эрхлэлтийн түвшин”-г аймаг, нийслэлээр дараах зургаар харууллаа.


ЗУРАГ 8. АЖИЛЛАГЧИД, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН, аймаг, нийслэлээр




Ажиллагчдын 131.2 (9.5%) мянга нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 1093.7 (79.3%) мянга нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан), 132.7 (9.6%) мянга нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) болон 22.6 (1.6%) мянга нь 65 ба түүнээс дээш насныхан байна.

Нийт ажиллагчдын 683.3 (49.5%) мянга нь үйлчилгээний салбарт, 317.4 (23.0%) мянга нь үйлдвэрлэлийн салбарт, 379.4 (27.5%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 9. ХӨДӨЛМӨРИЙН СТАТИСТИКИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, 2025 оны 1 дүгээр улиралд



ЗУРАГ 10. АЖИЛЛАГЧИД, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР, мянган хүнээр




Ажиллагчдыг эрхэлж буй ажлынх нь ажил мэргэжлээр авч үзвэл, 373.7 (27.1%) мянга нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын, 219.3 (15.9%) мянга нь мэргэжилтэн, 197.9 (14.3%) мянга нь худалдаа, үйлчилгээний, 148.6 (10.8) мянга нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний, 144.7 (10.5%) мянга нь суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагчийн, 109.8 (8.0%) мянга нь энгийн ажил, мэргэжлээр ажиллаж байна.

ХҮСНЭГТ 3. АЖИЛЛАГЧИД, ажил мэргэжлийн ангилал, хүйсээр

Ажил мэргэжлийн ангилал	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	1 380 098	100.0	751 337	100.0	628 762	100.0
Менежер	97 928	7.1	55 839	7.4	42 089	6.7
Мэргэжилтэн	219 267	15.9	77 171	10.3	142 096	22.6
Техникч болон туслах/ дэд мэргэжилтэн	40 191	2.9	23 386	3.1	16 805	2.7
Контор, үйлчилгээний ажилтан	37 164	2.7	9 955	1.3	27 209	4.3
Худалдаа, үйлчилгээний ажилтан	197 872	14.3	65 928	8.8	131 943	21.0
Хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан	373 735	27.0	215 253	28.7	158 482	25.2
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан	148 621	10.8	113 561	15.1	35 060	5.6
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	144 737	10.5	136 923	18.2	7 814	1.2
Энгийн ажил, мэргэжил	109 781	8.0	44 533	5.9	65 248	10.4
Зэвсэгт хүчний ажил, мэргэжил	10 803	0.8	8 788	1.2	2 016	0.3

Ажиллагчдын эрхэлж байгаа ажил мэргэжлийн ур чадварын түвшний хувьд авч үзэхэд 5 ажиллагч тутмын 3 нь дунд түвшний ур чадвар бүхий ажил мэргэжлээр ажиллаж байна. Харин өндөр ур чадвар бүхий түвшний ажил мэргэжлээр ажиллаж байгаа ажиллагчид 25.9 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 11. АЖИЛЛАГЧИД, ЭРХЭЛЖ БАЙГАА АЖИЛ МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН ТҮВШНЭЭР, улирлаар, дүнд эзлэх хувиар



Ажиллагчдыг ажиллаж буй байгууллагынх нь төрлөөр авч үзвэл, 493.1 (35.7%) мянга нь хувийн аж ахуйн нэгж байгууллагад, 350.5 (25.4%) мянга нь өрхийн аж ахуйд, 219.1 (15.9%) мянга нь төсөвт байгууллагад, 23.2 (1.7%) мянга нь төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газарт, 7.2 (0.5) орон нутгийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар, 14.4 (1.0%) мянга нь төрийн бус байгууллагад, 3.2 (0.2%) мянга нь олон улсын байгууллага, суурийн төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа бол 217.4 (15.8%) мянга нь хувийн бизнес эрхлэгч буюу хувь хүн, иргэд дийлэнх хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАГЧИД, АЖ АХУЙН НЭГЖ, байгууллагын төрлөөр, хүйсээр

Байгууллагын төрөл	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	тоо	%	тоо	%	тоо	%
Бүгд	1 380 098	100.0	751 337	100.0	628 762	100.0
Төрийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар	23 162	1.7	16 999	2.3	6 163	1.0
Орон нутгийн өмчит аж ахуйн оролцоотой үйлдвэрийн газар	7 210	0.5	2 909	0.4	4 301	0.7
Төсөвт байгууллага	219 089	15.9	80 954	10.8	138 135	22.0
Төрийн бус байгууллага (сүм, хийд)	14 388	1.0	9 278	1.2	5 110	0.8
ОУ-ын байгууллага, суурин төлөөлөгчийн газар	3 238	0.2	2 347	0.3	891	0.1
Хувьцаат компани	47 756	3.5	28 031	3.7	19 724	3.1
Хувийн аж ахуйн нэгж байгууллага	493 141	35.7	288 448	38.4	204 692	32.6
Хувийн бизнес буюу хувь хүн (ферм болон ХХК биш)	217 369	15.8	123 456	16.4	93 912	14.9
Өрхийн аж ахуй	350 462	25.4	196 928	26.2	153 534	24.4
Бусад	4 283	0.3	1 985	0.3	2 298	0.4

3. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

Улсын хэмжээнд хөдөлмөрийн дутуу ашиглалт 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 109.6 мянга байгаагийн 79.0 (72.0%) мянга нь **ажилгүй хүн**, 29.6 (27.0%) мянга нь **боломжит ажиллах хүч**, 1.1 (1.0%) мянга нь **цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид** байна. Хөдөлмөрийн дутуу ашиглалт өмнөх оны мөн үеэс 7.9 (6.7%) мянгаар буурсан, өмнөх улирлаас 21.5 (24.3%) мянган хүнээр өссөн байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөлмөрийн дутуу ашиглалтын бүлэг болох ажилгүй хүн 7.2 (10.0%) мянгаар өсөж, боломжит ажиллах хүч 6.8 (18.6%) мянгаар, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 8.4 (88.2%) мянгаар буурч, хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин 0.8 нэгж хувь, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 0.2 нэгж хувиар буурч, ажилгүйдлийн түвшин 0.3 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 12. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШНҮҮД, улирлаар




ХҮСНЭГТ 5. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ, хувиар, 2025 оны 1 дүгээр улиралд

Үзүүлэлт	Бүгд		Хүйсээр			
			Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Хөдөлмөрийн дутуу ашиглалт	109 628	100.0	64 063	58.4	45 565	41.6
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	1 121	100.0	621	55.4	500	44.6
Ажилгүй хүн	78 956	100.0	47 616	60.3	31 340	39.7
Боломжит ажиллах хүч	29 551	100.0	15 826	53.6	13 725	46.4
Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин, %		7.4		7.9		6.8
Ажилгүйдлийн түвшин, %		5.4		6.0		4.7
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин, %		5.5		6.0		4.8
Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин, %		7.3		7.8		6.7

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын үзүүлэлтүүдийг 15-24 насны (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 25-54 насны (ерөнхий ажиллах хүчний насныхан) болон 55-64 насны (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) бүлгээр харуулав. Хөдөлмөрийн дутуу ашиглалт 25-54 насныхан буюу ерөнхий ажиллах хүчнийхэн хамгийн их 82.7 мянга байна.

ЗУРАГ 13. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШНҮҮД, насны бүлгээр, хувиар, 2025 оны 1 дүгээр улиралд



Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг үнэлэх үзүүлэлтүүдийг аймаг, нийслэлээр авч үзэхэд, хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин Баян-Өлгий аймагт 13.8 хувьтай байгаа нь хамгийн өндөр, Төв аймагт 1.1 хувьтай байгаа нь хамгийн бага үзүүлэлттэй байна.

ХҮСНЭГТ 6. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ, бүс, аймаг, нийслэлээр

Аймаг, нийслэл	ЦХХББХЭ	Ажилгүй хүн	Боломжит ажиллах хүч	ХДА-ын нийлмэл түвшин	Ажилгүйдлийн түвшин	ЦХХББХЭ+АХ-ний нэгдсэн түвшин	БАХ+АХ-ний нэгдсэн түвшин
	мянган хүн			Хувь			
Дүн	1.1	79.0	29.6	7.4	5.4	5.5	7.3
Баруун бүс	1.1	17.6	3.4	11.4	9.2	9.8	10.8
Баян-Өлгий	0.3	5.8	1.0	16.4	13.7	14.4	15.7
Говь-Алтай	0.1	2.1	0.0	6.4	6.0	6.4	6.0
Завхан	0.1	3.9	1.0	13.8	11.1	11.4	13.5
Увс	0.6	2.5	0.2	8.0	6.1	7.5	6.6
Ховд	-	3.4	1.2	11.6	8.8	8.8	11.6
Хангайн бүс	-	13.5	3.5	6.2	5.0	5.0	6.2
Архангай	-	1.5	0.2	3.8	3.3	3.3	3.8
Баянхонгор	-	2.0	0.7	6.1	4.6	4.6	6.1
Булган	-	0.9	0.2	3.8	3.3	3.3	3.8
Орхон	-	3.2	0.0	9.9	9.9	9.9	9.9
Өвөрхангай	-	2.5	1.4	6.2	4.1	4.1	6.2
Хөвсгөл	-	3.4	1.0	7.0	5.4	5.4	7.0
Төвийн бүс	-	9.2	1.4	4.9	4.2	4.2	4.9
Говьсүмбэр	-	0.7	0.2	11.1	8.9	8.9	11.1
Дархан-Уул	-	3.0	0.5	8.7	7.5	7.5	8.7
Дорноговь	-	0.6	0.1	2.4	2.1	2.1	2.4
Дундговь	-	0.6	0.0	2.9	2.9	2.9	2.9
Өмнөговь	-	0.7	0.1	2.1	1.9	1.9	2.1
Сэлэнгэ	-	3.1	0.5	9.1	7.9	7.9	9.1
Төв	-	0.4	0.0	1.1	1.1	1.1	1.1
Зүүн бүс	-	8.1	1.4	8.7	7.5	7.5	8.7
Дорнод	-	4.0	0.7	11.8	10.2	10.2	11.8
Сүхбаатар	-	1.7	0.5	6.8	5.3	5.3	6.8
Хэнтий	-	2.4	0.2	7.0	6.5	6.5	7.0
Улаанбаатар	-	30.6	19.8	7.3	4.6	4.6	7.3


Тайлбар: - ЦХХББХЭ – цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч
 - БАХ – боломжит ажиллах хүч
 - АХ – ажилгүй хүн

3.1. Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч

Нийт ажиллагчдын 1.1 (0.1%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна. Эдгээр иргэд нь ажилгүй хүнтэй адил хөдөлмөрийн зах зээлд бүрэн ашиглагдахгүй байгаа хөдөлмөрийн нөөц гэж тооцогддог. Учир нь ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоолын дагуу “Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч” гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүн гэж тодорхойлсон. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (ХЭСҮТА-ийн заалт 2.16.1).


Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийн 69.2 хувь нь хөдөө орон нутагт байгаа ба хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх өндөр буюу 55.4 хувьтай байна.

ЗУРАГ 14. ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, насны бүлгээр



Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчдийг тухайн хугацаанд ажиллаж буй ажлын байран дахь ажил мэргэжлээр нь авч үзэхэд хамгийн их нь буюу 876 (78.2%) нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын мэргэшсэн ажилтан, 129 (11.5%) нь үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил, үйлчилгээний ажилтан, 116 (10.3%) нь контор, үйлчилгээний ажилтан байна. Мөн эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангиллаар авч үзэхэд ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын салбарт хамгийн их буюу 876 (78.2%) хүн, 116 (10.3%) нь үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт ажиллаж байна.

ЗУРАГ 15. ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, ажиллаж буй ажил мэргэжлээр, дүнд эзлэх хувиар



ЗУРАГ 16. ЦАГ ХУГАЦААНААС ХАМААРСАН БҮРЭН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, дүнд эзлэх хувиар



3.2. Ажилгүй хүн

Улсын хэмжээнд ажилгүй хүн⁵ 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 79.0 мянга байгаагийн 47.6 (60.3%) мянга нь эрэгтэйчүүд, 31.3 (39.7%) мянга нь эмэгтэйчүүд байна. Ажилгүй хүн өмнөх оны мөн үеэс 7.2 (10.0%) мянгаар, өмнөх улирлаас 3.6 (4.7%) мянгаар өссөн байна. Уг өсөлтийг насны бүлгээр авч үзэхэд, өмнөх оны мөн үеэс 25-29, 45-49, 60-64 насны бүлэгт 1.4-3.1 мянгаар, өмнөх улирлаас 40-44, 60-64, 30-34 насны бүлэгт 2.1-3.4 мянгаар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Ажилгүйдлийн түвшин улсын хэмжээнд 5.4 хувь, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 6.0 хувь, эмэгтэйчүүдийнх 4.7 хувь байна. Хот, суурин газрын хүн амын ажилгүйдлийн түвшин 6.4 хувь буюу улсын дунджаас 1.0 нэгж хувиар дээгүүр, харин хөдөө, орон нутагт ажилгүйдлийн түвшин 2.4 хувь байгаа нь улсын дунджаас 3.0 нэгж хувиар доогуур байна. Ажилгүйдлийн түвшнийг бүсээр харахад, баруун бүсэд 3.8 нэгж хувь, зүүн бүсэд 2.1 нэгж хувиар улсын дунджаас дээгүүр байна.

ХҮСНЭГТ 7. АЖИЛГҮЙ ХҮН, АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, хүйсээр, байршил, бүсээр

Байршил/ бүс нутаг	Ажилгүй иргэдийн тоо						Ажилгүйдлийн түвшин,%		
	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй		Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
	тоо	%	тоо	%	тоо	%			
Дүн	78 956	100	47 616	60.3	31 340	39.7	5.4	6.0	4.7
Хот	70 153	88.9	43 127	61.5	27 025	38.5	6.4	7.2	5.5
Хөдөө	8 804	11.1	4 489	51.0	4 315	49.0	2.4	2.2	2.6
Бүсээр:									
Баруун	17 585	22.3	10 617	60.4	6 968	39.6	9.2	10.3	8.0
Хангай	13 529	17.1	8 003	8003	5 525	40.8	5.0	5.4	4.5
Төв	9 195	11.6	5 653	61.5	3 542	38.5	4.2	4.8	3.6
Зүүн	8 058	10.2	4 931	61.2	3 127	38.8	7.5	8.4	6.4
Улаанбаатар	30 589	38.7	18 412	60.2	12 177	39.8	4.6	5.0	4.0

Улсын хэмжээнд 15-24 насны 11.6 мянган ажилгүй залуучууд байгаа нь нийт ажилгүй хүмүүсийн 14.7 хувийг эзэлж байгаа бөгөөд тухайн насны залуучуудын ажилгүйдлийн түвшин 8.1 хувьтай байна.


⁵Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

ХҮСНЭГТ 8. АЖИЛГҮЙ ХҮН, насны бүлгээр

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	78 956	100.0	47 616	100.0	31 340	100.0
15-19	4 097	5.2	3 133	6.6	964	3.1
20-24	7 486	9.5	6 417	13.5	1 068	3.4
25-29	12 120	15.3	6 411	13.5	5 709	18.2
30-34	12 808	16.2	7 284	15.3	5 524	17.6
35-39	10 774	13.6	5 139	10.8	5 636	18.0
40-44	11 367	14.4	6 203	13.0	5 164	16.5
45-49	8 461	10.7	4 760	10.0	3 701	11.8
50-54	6 384	8.1	3 644	7.7	2 741	8.7
55-59	2 557	3.2	2 261	4.7	296	0.9
60+	2 902	3.7	2365	5.0	538	1.7

Ажилгүйдлийн түвшнийг насны бүлгээр авч үзвэл, 15-19 (16.5%), 25-29 (6.8%) насны бүлгүүдэд хамгийн өндөр буюу улсын дунджаас 1.4 - 11.1 нэгж хувиар дээгүүр байна.

ЗУРАГ 17. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, насны бүлэг, хүйсээр




Ажилгүй хүмүүсийг боловсролын түвшнээр нь авч үзвэл, тодорхой мэргэжил эзэмших түвшний буюу техникийн болон мэргэжлийн, түүнээс дээш боловсролтой ажилгүй хүмүүс нийт ажилгүйчүүдийн 63.1 хувь байгаа бол үлдсэн 36.9 хувь нь бүрэн дунд болон түүнээс доош боловсролын түвшинтэй иргэд байна. Хөгжиж буй ихэнх орнуудад гол төлөв боловсрол доогуур буюу боловсролгүй хүн ам ажилгүй байдаг бол манай улсад боловсролтой иргэд илүү ажилгүй байх хандлагатай байна.

ХҮСНЭГТ 9. АЖИЛГҮЙ ХҮН, боловсролын түвшин, хүйсээр

Боловсролын түвшин	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	78 956	100.0	47 616	100.0	31 340	100.0
Боловсролгүй	2 135	2.7	1 118	2.4	1 017	3.2
Бага	2 035	2.6	1 181	2.5	855	2.7
Суурь	7 250	9.2	3 989	8.4	3 261	10.4
Бүрэн дунд	17 678	22.4	12 144	25.5	5 534	17.8
Техникийн болон мэргэжлийн	23 857	30.2	16 512	34.7	7 345	23.4
Тусгай мэргэжлийн дунд	4 526	5.7	2 970	6.2	1 556	5.0
Дипломын дээд	1 181	1.5	830	1.7	351	1.1
Бакалаврын дээд	19 643	24.9	8 348	17.5	11 296	36.0
Магистр	649	0.8	524	1.1	125	0.4


Ажилгүй хүмүүсийн 15.3 (19.3%) мянга нь урьд өмнө нь цалинтай ажил, бизнес эрхэлж байгаагүй бол 63.7 (80.7%) мянга нь өмнө нь хөдөлмөр эрхэлж байжээ. Өмнө нь ямар нэгэн хөдөлмөр эрхэлж байсан ажилгүй хүн амын сүүлийн ажлаасаа гарсан шалтгааныг авч үзвэл, 20.8 (32.6%) мянга нь өөрийн хүсэлтээр, 11.1 (17.4%) мянга нь хувийн гэр бүлийн шалтгаанаар, 6.3 (9.9%) мянга нь түр ажлын байранд ажиллаж байсан гэж хариулсан нь хамгийн өндөр хувийг эзэлж байна.

ЗУРАГ 18. АЖИЛГҮЙ ХҮН, өмнөх ажлаасаа гарсан шалтгаанаар, дүнд эзлэх хувиар



3.3. Боломжит ажиллах хүч

ЗУРАГ 19. БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ, бүсээр, дүнд эзлэх хувиар



Улсын хэмжээнд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт хөдөлмөрийн дутуу ашиглалтын 29.6 (27.0%) мянга нь цалин хөлс, орлого олох ажил хайх эсвэл хийх нөхцөл нь бүрдвэл ажилгүй хүний эгнээнд шилжихэд бэлэн байгаа боломжит ажиллах хүчинд багтаж байна. Эдгээр иргэд нь ажилгүй хүнтэй адил хөдөлмөрийн зах зээлд бүрэн ашиглагдахгүй байгаа

хөдөлмөрийн нөөц гэж тооцогддог. Учир нь боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүнийг хэлнэ.

Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 6.8 (18.6%) мянгаар буурсан, өмнөх улирлаас 18.6 (1.7 дахин) мянгаар өссөн байна. Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс буурахад дийлэнх насны бүлэгт 0.2-2.5 мянгаар буурсан нь, өмнөх улирлаас өсөхөд дийлэнх насны бүлэгт 0.8-4.1 мянгаар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Боломжит ажиллах хүчний 27.6 (91.4%) мянга нь хот, суурин газрынх, 15.8 (53.6%) мянга нь эрэгтэйчүүд байна. Нийт боломжит ажиллах хүчний 19.8 (67.1%) мянга нь Улаанбаатар хотод байна. Мөн бүсээр харвал 3.4 (11.6%) мянга нь баруун бүсэд, 3.5 (11.7%) мянга нь Хангайн бүсэд, 1.4 (4.8%) мянга нь Төвийн бүсэд, 1.4 (4.8%) мянга нь Зүүн бүсэд байна.

ХҮСНЭГТ 10. БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ, насны бүлэг, хүйсээр, дүнд эзлэх хувиар

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	29 551	100.0	15 826	100.0	13 725	100.0
15-19	1 243	4.2	849	5.4	394	2.9
20-24	4 587	15.5	1053	6.7	3534	25.7
25-29	1 841	6.2	1270	8.0	571	4.2
30-34	3 895	13.2	1864	11.8	2031	14.8
35-39	6 600	22.3	5058	32.0	1542	11.2
40-44	2 380	8.1	858	5.4	1522	11.1
45-49	2 186	7.4	812	5.1	1374	10.0
50-54	2 889	9.8	2110	13.3	779	5.7
55-59	1 874	6.3	803	5.1	1071	7.8
60-64	2 055	7.0	1149	7.3	907	6.6


ХҮСНЭГТ 11. ИТГЭЛ АЛДАРСАН АЖИЛ ХАЙГЧИД, насны бүлэг, хүйсээр

Насны бүлэг	Бүгд		Эрэгтэй		Эмэгтэй	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Бүгд	5 031	100.0	2 525	100.0	2 505	100.0
15-19	284	5.6	284	11.2	-	-
20-24	100	2.0	100	4.0	-	-
25-29	-	-	-	-	-	-
30-34	190	3.8	190	7.5	-	-
35-39	-	-	-	-	-	-
40-44	79	1.6	79	3.1	-	-
45-49	759	15.1	303	12.0	456	18.2
50-54	799	15.9	238	9.4	561	22.4
55-59	1078	21.4	497	19.7	581	23.2
60-64	1742	34.6	835	33.1	907	36.2

Боломжит ажиллах хүчний 5.0 (17.0%) мянга нь итгэл алдарсан ажил хайгчид байна. Итгэл алдарсан ажил хайгч гэж ажил хийх боломжтой байгаа ч хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой ажил хайгаагүй, ажлын байр хайсан ч олох найдвараа алдсан хөдөлмөрийн насны хүн ам юм. Хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой гэдэг нь мэргэжил, туршлага байхгүйгээс тохирох ажлын байр олж авч чадахгүй байгааг, хэтэрхий залуу, хөгшин байна гэсэн шалтгаанаар ажил олгогчдын шаардлагад нийцэхгүй байгааг ойлгоно.

Боломжит ажиллах хүчний 11.8 (57.5%) мянга нь сүүлийн 30 хоногт цалин, хөлстэй ажил хайгаагүй, бизнес эрхлэх оролдлого хийгээгүй ч ажил хийх боломжтой байна. Тэдгээр хүн амын цалинтай ажил хайх эсвэл бизнес эрхлэх ямар нэгэн оролдлого хийгээгүй шалтгааныг дараах зургаар харууллаа.

ЗУРАГ 20. СҮҮЛИЙН 30 ХОНОГТ АЖИЛ ХАЙГААГҮЙ БОЛОМЖИТ АЖИЛЛАХ ХҮЧ, ажил хайгаагүй шалтгаан, дүнд эзлэх



- Улирлаас шалтгаалаад, хөдөлмөр эрхлэх боломж эхлэхийг нь хүлээж
- Гэр бүлийн шалтгаанаар
- Өвчтөн, хөгжлийн бэрхшээлтэй
- Ур чадварт тохирох ажил байхгүй туршлага байхгүй
- Ажил олгогчдын зүгээс хэтэрхий залуу/хөгшин байна гэж үздэг
- Өмнөх ажлаас утасдахыг хүлээж байгаа
- Суралцаж байсан, сургалтад хамрагдаж байгаа
- Ажил олгогчид эрэгтэй/эмэгтэй хүн ажилд авахыг илүүд үздэг
- Ажил хайгаад залхсан ажлын байр байхгүй гэж бодож байна
- Бусад орлогын эх үүсвэртэй
- Өмнөх ажил хайлтын үр дүнг хүлээж байна
- Бусад

4. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ

Улсын хэмжээнд 15, түүнээс дээш насны нийт хүн амын 893.7 (38.0%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам, тэдгээрийн 29.6 (3.3%) мянга нь боломжит ажиллах хүч (ажил хайсан, хийхэд бэлэн биш эсвэл ажил хайгаагүй ч хийхэд бэлэн), 864.2 (96.7%) мянга нь бусад ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна.

ЗУРАГ 21. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН БҮТЭЦ, мянган хүн болон дүнд эзлэх хувиар



Ажиллах хүчнээс гадуурх хүн амыг насны бүлгээр авч үзвэл, 15-19 насны залуучуудын хувь хамгийн өндөр (26.3%) байгаа нь тэдний сургуульд хамрагдалттай холбоотой юм. Харин ажил, хөдөлмөр эрхлэх боломжтой буюу 25-59 насныхан нийт ажиллах хүчнээс гадуурх хүн амын 33.9 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 12. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, бүс, насны бүлгээр

Насны бүлэг	Ажиллах хүчнээс гадуурх хүн ам		Үүнээс, хувийн жингээр	
	Тоо	%	Боломжит ажиллах хүч	%
Бүгд	893 727	100.0	29 551	3.3
15-19	245 452	27.5	1 243	0.5
20-24	89 651	10.0	4 587	5.1
25-29	43 337	4.8	1 841	4.2
30-34	41 558	4.6	3 895	9.4
35-39	49 906	5.6	6 600	13.2
40-44	36 042	4.0	2 380	6.6
45-49	32 801	3.7	2 186	6.7
50-54	42 782	4.8	2 889	6.8
55-59	61 871	6.9	1 874	3.0
60-64	85 196	9.5	2 055	2.4
65-69	70 749	7.9	-	-
70+	94 383	10.6	-	-

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам өмнөх оны мөн үеэс 56 (0.01%) хүнээр өссөн өсөлтийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцохгүй байгаа шалтгаанаар нь авч үзэхэд жирэмсэн хүүхэд асарсан (20.6 мянгаар), суралцдаг (7.7 мянгаар), хөгжлийн бэрхшээлтэй (5.1 мянгаар), өвчтэй (2.0 мянгаар) гэх шалтгаантай хүмүүсийн тооны өсөлт голлон нөлөөлсөн байна.

ЗУРАГ 22. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМЫН ӨӨРЧЛӨЛТ, ажилгүй байгаа шалтгаанаар, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, мян.хүн



Бусад ажиллах хүчнээс гадуурх хүн амын 35.8 хувь нь боловсрол, сургалтад хамрагддаг сурагч болон оюутан, 34.6 хувь нь ахмад настны тэтгэвэрт гарсан, 14.2 хувь нь жирэмсэн эмэгтэйчүүд, эсвэл хүүхдээ асарч байгаа эцэг, эхчүүд, 5.1 хувь нь өвчтэй иргэд байна.

ХҮСНЭГТ 13. АЖИЛЛАХ ХҮЧНЭЭС ГАДУУРХ ХҮН АМ, шалтгаанаар, мянган хүнээр

Шалтгаан	Боломжит ажиллах хүч				Бусад АХГХА			
	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд		Эрэгтэй	Эмэгтэй
	Тоо	Хувь	Тоо	Тоо	Тоо	Хувь	Тоо	Тоо
Бүгд	29.6	100.0	15.8	13.7	864.2	100.0	310.9	553.3
Хөдөлмөрийн нас хүрээгүй	1.4	4.6	0.4	1.0	301.0	34.8	141.7	159.3
Суралцдаг	3.1	10.4	1.3	1.8	296.1	34.3	93.0	203.1
Тэтгэвэрт гарсан	5.3	17.9	0.5	4.8	126.6	14.6	4.8	121.8
Өвчтэй	0.9	3.0	0.9	-	42.8	4.9	24.4	18.4
Хөгжлийн бэрхшээлтэй	1.8	6.1	1.3	0.4	41.3	4.8	18.7	22.7
Жирэмсэн/хүүхэд асарсан	3.0	10.1	1.2	1.8	10.7	1.2	2.8	7.9
Бусдыг асарсан	1.8	6.2	0.5	1.3	8.5	1.0	1.4	7.1
Тухайн жилд сургууль төгссөн	0.3	1.0	0.3	-	8.3	1.0	4.3	4.0
Аав, ээж, гэр бүл, үр хүүхдээ дагаад	7.3	24.7	7.0	0.3	5.5	0.6	3.5	2.0
Хүүхдээ сургуульд сургахаар	0.3	1.1	0.2	0.1	3.1	0.4	2.1	1.0
Гадаадад амьдарч байгаад ирсэн	0.2	0.7	0.2	-	3.0	0.3	1.8	1.1
Байгууллага татан буугдсан	0.3	1.1	0.0	0.3	2.8	0.3	2.1	0.7
Цомхотголд орсон	2.0	6.7	1.1	0.9	2.6	0.3	1.1	1.5
Улирлаас хамаарч ажлын байр олддог	-	-	-	-	1.9	0.2	1.7	0.2
Мэргэжил, дадлага туршлага байхгүй	-	-	-	-	1.6	0.2	0.5	1.0
Мэргэжилд тохирох ажил олдохгүй	-	-	-	-	1.2	0.1	1.2	-
Ажил хайгаад олдохгүй байгаа	0.1	0.3	-	0.1	1.1	0.1	0.9	0.2
Байгалийн гамшиг, аюулт үзэгдэлд өртөж малгүй болсон (ган, зуд, үе)	1.0	3.3	0.5	0.5	0.6	0.1	-	0.6
Ажиллах сонирхолгүй байсан	0.1	0.3	0.1	-	0.5	0.1	0.4	0.2
Цалин бага учраас	-	-	-	-	0.5	0.1	0.5	-
Малчин	-	-	-	-	0.2	-	0.2	-
Бусад	0.7	-	0.3	0.4	4.4	0.5	4.0	0.4

5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ХАМРАГДААГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУД

Залуучуудын ажилгүйдлийн түвшний үзүүлэлт нь залуучуудын хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх зарим мэдээллийг илэрхийлнэ. Өөрөөр хэлбэл эдгээр тоо мэдээлэл нь залуучуудад тулгарч буй асуудлыг бүрэн илэрхийлж чадахгүй бөгөөд шийдвэр гаргах үйл явцад үүнээс дэлгэрэнгүй, бодитой мэдээлэл шаардлагатай. Харин хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын талаарх үзүүлэлт нь ажилгүй залуучууд гэхээсээ илүүтэйгээр хөдөлмөрийн зах зээлд шинээр орж ирэх боломжтой ажиллах хүчний нөөцийн хэмжүүр болж өгдөг. Үүнд ажил хайхаас шантарсан залуучууд болон хөгжлийн бэрхшээлтэй, гэр орныхоо ажилд тусалдаг гэх зэрэг бусад олон шалтгаанаар ажиллах хүчнээс гадуур байгаа залуучууд хамрагдана.


Улсын хэмжээнд 2024 оны 3 дугаар улиралд 15-24 насны 53.0 мянган залуучууд ямар нэгэн боловсрол, сургалтад хамрагдаагүй, мөн цалин, орлого олох хөдөлмөр эрхлээгүй байна. Өөрөөр хэлбэл, 15-24 насны нийт залуучуудад боловсрол, сургалтад хамрагдаагүй байгаа залуучуудын эзлэх хувийн жин 11.6 хувь (эрэгтэй 9.5%, эмэгтэй 13.8%) байна.

СУРАГ 23. 15-24 НАСНЫ НИЙТ ЗАЛУУЧУУДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ХАМРАГДААГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, ХҮЙСЭЭР



Хөдөлмөр эрхлээгүй, боловсрол, сургалтад хамрагдаагүй 15-24 насны залуучуудын 53.4 хувь нь бүрэн дунд болон түүнээс бага боловсролын түвшинтэй, 46.6 хувь нь техник, мэргэжлийн боловсрол болон түүнээс дээш боловсрол түвшин буюу тодорхой түвшний мэргэжил эзэмшсэн байна.

СУРАГ 24. 15-24 НАСНЫ НИЙТ ЗАЛУУЧУУДАД ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ, БОЛОВСРОЛ, СУРГАЛТАД ХАМРАГДААГҮЙ БАЙГАА ЗАЛУУЧУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, БОЛОВСРОЛЫН ТҮВШНЭЭР, ХҮЙСЭЭР



ДҮГНЭЛТ

1. Ажиллагчдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 47.5 (3.6%) мянгаар, өмнөх улирлаас 26.7 (2.0%) мянгаар өсөж 1380.1 мянга болсон байна.
2. Нийт ажиллагчдын 683.3 (49.5%) мянга нь үйлчилгээний салбарт, 317.4 (23.0%) мянга нь үйлдвэрлэлийн салбарт, 379.4 (27.5%) мянга нь хөдөө аж ахуйн салбарт ажиллаж байна.
3. Ажиллагчдыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөдөө аж ахуй, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуурын (37.4 мянгаар), боловсруулах үйлдвэрлэл (21.3 мянгаар), тээвэр ба агуулахын үйл ажиллагаа (14.4 мянгаар), үйлчилгээний бусад үйл ажиллагаа (9.8 мянгаар), зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээ (6.8 мянгаар), бөөний болон жижиглэн худалдаа, машин мотоциклийн засвар үйлчилгээ (4.2 мянгаар), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (3.6 мянгаар) салбарын ажиллагчид тус тус өссөн байна. Харин хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа (19.3 мянгаар), санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа (13.0 мянгаар), цахилгаан, хий, уур, агааржуулалт (4.1 мянгаар), мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа (4.1 мянгаар) салбарын ажиллагчид тус тус буурсан байна.
4. Ажиллагчдыг өмнөх улиралтай харьцуулахад, ХАА, ойн аж ахуйн, загас барилт, ан агнуур салбарынх 58.1 (18.1%) мянгаар, боловсруулах үйлдвэрлэл 26.5 (26.2%) мянгаар, уул уурхай олборлолт 13.6 (20.3%) мянгаар тус тус өссөн бол боловсролын салбарын ажиллагчид 25.0 (19.2%) мянгаар, барилгын салбарын ажиллагчид 13.8 (14.4%) мянгаар буурсан байна.
5. Ажиллагчдын 131.2 (9.5%) мянга нь 15-24 насныхан (боловсрол, сургалтын дараах хөдөлмөрийн зах зээлд шинээр орж байгаа залуучууд), 1093.7 (79.3%) мянга нь 25-54 насныхан (ерөнхий ажиллах хүчний насныхан), 132.7 (9.6%) мянга нь 55-64 насныхан (тэтгэвэрт гарахад ойрхон байгаа) болон 22.6 (1.6%) мянга нь 65 ба түүнээс дээш насныхан байна.
6. Нийт ажиллагчдын 1.1 (0.1%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.
7. Улсын хөдөлмөрийн дутуу ашиглалт 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 109.6 мянга байгаагийн 79.0 (72.0%) мянга нь ажилгүй хүн, 29.6 (27.0%) мянга нь боломжит ажиллах хүч, 1.1 (1.0%) мянга нь цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид байна.
8. Хөдөлмөрийн дутуу ашиглалт өмнөх оны мөн үеэс 7.9 (6.7%) мянгаар буурсан, өмнөх улирлаас 21.5 (24.3%) мянган хүнээр өссөн байна.
9. Боломжит ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 6.8 (18.6%) мянгаар буурсан, өмнөх улирлаас 18.6 (1.7 дахин) мянгаар өссөн байна.
10. Ажиллах хүчний оролцооны түвшин 62.0 хувь, хүйсийн хувьд эрэгтэйчүүдийнх 71.0 хувь, эмэгтэйчүүдийнх 53.8 хувьтай байна. Эрэгтэйчүүдийн АХОТ эмэгтэйчүүдийнхээс 17.2 нэгж хувиар өндөр байна.
11. Хөдөлмөр эрхлэлтийн түвшин 58.7 хувь, хүйсээр авч үзэхэд эрэгтэйчүүдийнх 66.7 хувь, эмэгтэйчүүдийнх 51.2 хувь байна. Эрэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшин эмэгтэйчүүдийнхээс 15.5 нэгж хувиар өндөр байна.